

## ХИЧЭЭЛ 1

УНШИХ ЗҮЙЛ: ҮЙЛС 2:42-47; 4:32-35; ДАГАЛДАГЧДЫН ҮЙЛС, Х. 70-76.

# Шинэ Нөхөд

Та нар хүмүүстэй хамт оройн хоол идэх дуртай юу? Олон жилийн өмнө зарим хүмүүс дөнгөж Есүсийн тухай олж сонсжээ. Нэгэн бяцхан охин, ээж хоёр хэрхэн тэдэнтэй хоолоо хуваалцсан тухай төсөөлөн бодоцгооё.

**Б**

яцхан Дебора минь, чи их сайн ажил хийж байна" гэж ээж нь инээмсэглэн хэлэв. "Бид өнөө орой дахиад хүмүүстэй хамт оройн хоолоо идэх болно."

Дебора дээш хараад "Хэн ирэх юм бэ?" гэж асуулаа.

"Одоохондоо сайн мэдэхгүй байна" гэж ээж нь нүдээ ирмэн хэлэв.

Ээж нь Дебораг өвөр дээрээ суулгаад улаахан хацар дээр нь үнсээд "Ээж нь охиндоо тайлбарлаж өгье" гэжээ.

Дагалдагчид манай хотоор явж Есүсийн

тухай олон зүйлийг ярьж байгаа гэдгийг чи мэднэ шүү дээ. Өдөр болгон олон зуун хүмүүс Есүсийн тухай мэдэж авцгааж байгаа" гэж ээж нь яриагаа эхэлсэн юм.

Дебора толгой дохив. "Алс холоос ирсэн олон хүмүүс шинээр Есүст итгэцгээжээ. Тэд нэгэн том баяр тэмдэглэх гэж Иерусалимд хотод ирцгээсэн юм. Тэд дагалдагчдын яриаг сонсож, Есүсийн тухай олон зүйлийг олж мэджээ. Иерусалим хотод дахиад жаахан байж түүний тухай бүр илүү зүйлийг тэд мэдэхийг хүсэж байна. Гэхдээ тэдний зарим нь бүр холоос ирсэн болохоор мөнгөгүй болчихсон гэнэ. Тийм учраас бид



### Цээжлэх Ишлэл:

"Тэдний бүх юм нь нийтийнх байв"  
үйлс 4:32.

### Тол Санаа:

Бурханы хүүхдүүд байгаа зүйлээ хуваалцдаг.



тэдэнд тусалж байгаа юм. Бид оройн хоолоо тэдэнтэй хуваалцаж, Бурханы хайрыг хуваалцах болно."

Дебора ээжийнхээ өвөр дээрээс үсэрч буугаад, "Тэгвэл би хурдхан хогоо шүрдэж дуусгая" гэлээ.

Ээж нь талхныхаа гурилыг зуурав. Тэрээр гурилаа нухаад дараа нь илдлээ. Тэгээд тасалж хэдэн хэсэг болгожээ. Бөөрөнхий болгосон зуурмагнуудаа зуухандаа хийв. Удалгүй шинэхэн талхны сайхан үнэр гэрээр дүүрэн үнэртлээ.

Хаалга тогшиж ээжийнх нь найзууд дуу шуугиан болсоор орж ирлээ. "Надад жаахан шош бий" гэж тэрээр хэлээд ширээнд нэгэн хүнд ууттай зүйл тавив. "Та үүнийг хоолондоо хийгээсэй гэж би бодсон юм" гэж тэр инээмсэглэн өгүүллээ.

"Ээж, ямар их шош бэ?" гэж бяцхан Дебора хэлэв.

"Тийм шүү" гэж ээж нь толгой дохиод, Деборагаар нөгөө ууттай зүйлээ ширээн дээрээс аваад өргүүлж үзүүлэв. "Бурхан бидэнд илүү хоол хүнс өгдөг. Үүгээр маш их шөл хийж болно. Бурхан өнөөдөр оройн хоолон дээр олон хүн ирүүлэхийг хүсжээ."

"За миний хайртай гэр бүл юу хийж байна даа" гэх аавынх нь дуу гэр дүүрэн хадав. Тэрээр бяцхан Дебораг сэвхийтэл өргөөд чанга тэвэрлээ. Ээжийг нь ч бас тэр тэврэв. "Шөл ямар сайхан үнэртэж байнаа?" гэж аав тогоо руу өнгийн хэлжээ. "Та хоёр Иерусалимын хотын хамгийн сайхан амттай шөл хийжээ."

"Бид оройн хоолоо хуваалцаж байгаа" гэж Дебора хэлэв. Тэрээр шалан дээр эргэлдэнгээ "Бид Бурханы хайрыг шинэ итгэгчидтэй хуваалцаж байгаа" гэж хэлжээ.

"Би мэднэ. Намайг гэрээ цэвэрлээд дуусахаар бүгдээрээ төлөөлөгчдийн сургаал зааж байгаа газар руу явцгаана шүү. Тэнд очоод өөр итгэгчдийг олж гэртээ авчраад хоолоор дайлцгаая. Бүх зүйлийг сайхан бэлдсэн байгааг чинь хараад би баяртай байна" гэж аав нь хэллээ.

"Тэгээд бас хоол идэж байх зуураа бүгдээрээ Есүсийн тухай ярьцгаана. Энэ бол хамгийн сайхан зүйл" гэж Дебора баярлан хэлжээ.



# Дасгал Ажил



## ШАББАТ

Энэ долоо хоногийн өдөр бүр хичээл дээр үзсэн түүхийг уншаад цээжлэх ишлэлээ давтаарай.

**Тэдний**.....Бусад руу заах.

**бүх юм нь** .....Гараа алдлах.

**нийтийнх байв.** .....Юм өгөх мэт гараа урагш нь сунгах.

**Үйлс 4:32**.....Алгаа нийлүүлээд дэлгэнэ.


## НЯМ

Шаббат хичээлээсээ хуваалцахаар авчирсан зүйлээ хэн нэгтэй хуваалцахад нь хүүхдээ урамшуулаарай. Эсвэл хүүхдэдээ энгийн идэх юм бэлдэж өгөөд хэн нэгтэй хуваалцаарай. Иерусалим хотын хүмүүс байсан бүх зүйлээ хэрэгцээ шаардлагатай байгаа хүмүүстэй хэрхэн хуваалцсан тухай ярьж өгөөрэй.

## ДАВАА

"Сайн мэдээ" ном хийхэд нь хүүхдэдээ туслаарай. Тэгш өнцөгт хэлбэртэй цаас сониноос хайчилж аваад голоор нь нугалаад дотор талд нь цагаан цаас хийнэ үү. "Есүс чамд хайртай" гэж бичээрэй. Үүнийг илэрхийлсэн зургийг ч мөн зураарай. Дараа нь "сайн мэдээ" номыг хэн нэгтэй хүүхдээрээ хуваалцуулна уу.

Оройн хоолондоо хэдэн шинэ итгэгчдийг урьсан мэт жүжиглээрэй.



## МЯГМАР

Хүүхэдтэйгээ ямар нэг тусгай хоол хувааж идээрэй. Асуух: Хүмүүс чамтай хуваалцахгүй байхад чамд ямар сэтгэгдэл төрдөг вэ? Харин тэд чамтай хуваахад ямар байдаг вэ? Есүсийг яагаад биднийг юмаа хуваалцдаг байхыг хүсдэг юм бол?

## ЛХАГВА

Сүмээсээ хэн нэг шинэ хүнийг Шаббат өдрийн орой хоол хамт идэхийг уриарай. Эсвэл хүүхэд тань хамт тоглох гэж эсвэл хамт хоол идэх гэж нэг найзаа уриг. Залбирлынхаа өмнө хамтдаа хуваалцах тухай дуу дуулаарай.



## ПҮРЭВ

Үйлс 2:42-47 болон 4:32-35 -г хамтдаа уншаарай. Асуух: Гэрээсээ хол тэгээд бас хоолгүй, орох газаргүй

байвал ямар байх бол? Тэгвэл бид хэрэгцээтэй байгаа хүмүүстэй юу хуваалцаж болох вэ? Хүүхэдтэйгээ хамт ямар нэг зураг будахдаа өнгийн харандаагаа хувааж хэрэглээрэй.

## БААСАН

Гэрийнхэнтэйгээ хамт Библийн түүхийг жүжиглээрэй. Хуваалцаж болох зүйлсийг ч мөн оруулаарай. Жишээ нь: хоол, хөнжил, хувцас г.м. Энэ долоо хоног хэн хэнтэй юу хуваалцсан тухай нь гэрийнхнээрээ яриулаарай. Мөн тэдний төлөө залбираарай.